

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2024/51/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Орхон аймаг
2024 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Аудитор: О.Гантуяа
Утас: 70355805 Цахим хаяг: gantuyao@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	27
4.1 Ерөнхий зүйл.....	27
4.2 Материаллаг байдал.....	27
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	27
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	27
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	28
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	29
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	29
5.1 Төлбөрийн акт	29
5.2 Албан шаардлага.....	29
5.3 Зөвлөмж.....	29
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	31

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЗГНХ,ЗДНХ	Хөрөнгө Засгийн газрын нөөц хөрөнгө, Засаг даргын нөөц хөрөнгө
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
УТ	Улсын төсөв
ОНТ	Орон нутгийн төсөв



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2024.02.25 № 66

танай _____-ны № _____-г

ОРХОН АЙМГИЙН БАЙГАЛЬ
ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГА
С.ЖАРГАЛСАЙХАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 5 нэр төрлийн 4,268.7 мянган төгрөгийн хөрөнгийг Орхон аймгийн 20 дугаар сургуульд, эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй 11,000.0 мянган төгрөгийн усны хэмжигчийг Эрдэнэт-ус ДТС ОНӨК-д тус тус шилжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар нь 2023 оны орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 60,554.9 мянган төгрөгийн зөвлөх үйлчилгээний 2 судалгааны ажлыг үндсэн хөрөнгийн дансанд орлогодсон байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд Байгаль орчин аялал жуулчлалын газар нь орон нутгийн төсвийн хөрөнгөөр 23 төсөл хөтөлбөрийг 443,600.0 мянган төгрөгөөр хэрэгжүүлэхээр

төлөвлөснөөс 420,079.8 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй 22,520.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж, төсөл хөтөлбөрийн хэрэгжилт 94.6 хувьтай хэрэгжсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2024.09.25 № 107

танай _____ -ны № _____ -т

ОРХОН АЙМГИЙН БАЙГАЛЬ
ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГА
С.ЖАРГАЛСАЙХАН ТАНАА

**2023 оны санхүүгийн тайлангийн
аудитын тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2023 оны санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийлээ.

Аудитын тайлан, аудитын дүгнэлт болон аудитаар илэрсэн 371.8 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж, 7,700.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 565.0 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоосныг хүргүүлж байна.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.” гэж заасныг хэрэгжүүлж төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 30 хоногийн дотор, төлбөрийн актыг бүрэн барагдуулж, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРМАНДАХ



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 65/А1440340

Эрдэнэт

ОРА-2024/51/НА-СТА-ТУС

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгаль орчны салбарын тэмдэглэлт өдрүүдийг орон нутагт сурталчлах ажлыг зохион байгуулах арга хэмжээнд зориулж 7,700.0 мянган төгрөгөөр гарын авлага, ном хэвлүүлэн нөөцөлж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Гарын авлага, ном хэвлүүлэн нөөцөлж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх.

¹ Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-7812

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга (С.Жаргалсайхан), нягтлан бодогч (Д.Мөнхнасан) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР: Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР: Б.БУЯН-УНДРАХ

АУДИТОР: О.ГАНТУЯА



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 136/А/1440340

Эрдэнэт хот

ОРА-2024/51/НА-СТА-ТЦУЗ

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын бараа материалын үлдэгдэлд түүвэрлэн биет тооллого хийхэд 300,000 төгрөгийн бараа материал дутсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн өмчийн тухай хуулийн 71.2-т "бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар нь бараа материалын тооллогоор дутсан 300,000 (Гурван зуун мянга) төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 (Ор.хүү торгуулийн орлого) тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга (С.Жаргалсайхан), нягтлан бодогч (Д.Мөнхнасан) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ 
АУДИТОР:.....Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН 
МЕНЕЖЕР:.....Б.БУЯН-УНДРАХ

АУДИТОР: .....О.ГАНТУЯА



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 125/А 1470340

Эрдэнэт хот

ОРА-2024/51/НА-СТА-ТЦУЗ

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 265,000 төгрөгийн шатахууныг анхан шатны баримтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

- Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар нь анхан шатны баримтгүй зарцуулсан 265,000 (Хоёр зуун жаран таван мянга) төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 (Ор.хүү торгуулийн орлого) тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга (С.Жаргалсайхан), нягтлан бодогч (Д.Мөнхнасан) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР:..........Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР:..........Б.БУЯН-УНДРАХ

АУДИТОР:..........О.ГАНТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	222,177,240.36	224,282,267.36
35	БАРАА МАТЕРИАЛ	222,177,240.36	224,282,267.36
351	Түүхий эд материал	205,802,005.35	195,237,405.35
35110	Тусгай зориулалттай материал	205,802,005.35	195,237,405.35
354	Хангамжийн материал	16,375,235.01	29,044,862.01
35410	Бичиг хэргийн материал	00.00	369,500.00
35430	Сэлбэг хэрэгсэл	300,000.00	300,000.00
35440	Түлш, шатах тослох материал	5,785,000.01	4,135,127.01
35470	Бусад хангамжийн материал	10,290,235.00	24,240,235.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	562,675,065.43	575,938,040.26
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	562,675,065.43	575,938,040.26
392	Биет хөрөнгө	511,628,398.93	464,903,140.26
39201	Барилга, байгууламж, орон сууц	74,384,726.49	74,384,726.49
39202	Хуримтлагдсан элэгдэл	-14,722,149.12	-18,115,499.40
39203	Авто-тээврийн хэрэгсэл	197,019,560.00	197,019,560.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-15,856,365.58	-37,375,115.50
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	106,683,200.00	126,196,229.47
39206	Хуримтлагдсан элэгдэл	-33,919,558.29	-47,860,414.26
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	40,553,488.00	39,988,188.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-23,066,914.02	-24,826,748.55
39214	Бусад үндсэн хөрөнгө	253,549,480.37	253,549,480.37
39215	Хуримтлагдсан элэгдэл	-72,997,068.92	-98,057,266.36
393	Биет бус хөрөнгө	51,046,666.50	111,034,900.00
39301	Програм хангамж	21,195,000.00	21,195,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-20,628,333.50	-21,195,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	50,480,000.00	111,034,900.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	784,852,305.79	800,220,307.62
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	784,852,305.79	800,220,307.62
51	Засгийн газрын хувь оролцоо	784,852,305.79	800,220,307.62
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	161,706,475.95	161,706,475.95
51101	Өмч: - төрийн	161,706,475.95	161,706,475.95
512	Хуримтлагдсан үр дүн	616,927,874.96	632,295,876.79
51210	Өмнөх үеийн үр дүн	616,927,874.96	616,927,874.96
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	15,368,001.83
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,217,954.88	6,217,954.88
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	784,852,305.79	800,220,307.62

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,140,000.00	4,463,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	80,000.00	00.00
210602	Тавилга	00.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	00.00
210604	Урсгал засвар	2,060,000.00	4,463,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,370,000.00	3,548,400.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	5,370,000.00	3,548,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	575,160,836.50	137,220,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	572,929,936.50	134,868,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	990,000.00	594,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	222,750.00	223,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	298,695.00	340,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	323,000.00	772,000.00
210807	Газрын төлбөр	330,455.00	378,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,806,897.31	73,349,328.03
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	500,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	54,806,897.31	72,849,328.03
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	253,714,670.68	40,118,244.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,089,250.00	18,042,299.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	11,271,299.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,089,250.00	6,771,000.00
213404	Хөрөнгийн		
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	250,625,420.68	22,075,945.46
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	373,375,404.19	26,976,528.44
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	165,406,111.16	11,608,526.61
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	165,406,111.16	608,526.61
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	11,000,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-165,406,111.16	-11,608,526.61
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	207,969,293.03	15,368,001.83

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,200,130,100.00	609,677,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	100,000.00	550,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	100,000.00	550,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	100,000.00	550,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	550,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,200,030,100.00	609,127,600.00

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	958,693,400.00	95,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрсөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	958,693,400.00	95,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	241,336,700.00	514,127,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	241,336,700.00	514,127,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,194,130,100.00	606,678,795.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,194,130,100.00	606,678,795.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	940,415,429.32	566,560,550.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	229,475,096.54	405,501,374.90
210101	Үндсэн цалин	130,743,135.00	205,187,163.47
210102	Нэмэгдэл	42,327,061.00	163,925,546.87
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,200,300.00	24,611,998.56
210104	Урамшуулал	43,204,600.54	11,776,666.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,369,275.78	50,687,673.08
210201	Тэтгэврийн даатгал	19,467,307.76	34,467,617.29
210202	Тэтгэмжийн даатгал	2,141,696.78	4,055,013.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,832,237.70	3,244,011.03
210204	Ажилгүйдлийн даатгал	425,987.78	811,002.79
210205	Эрүүл мэндийн даатгал	4,502,045.76	8,110,028.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,229,013.00	4,948,352.56
210301	Гэрэл, цахилгаан	1,678,040.00	1,773,376.00
210302	Түлш, халаалт	836,593.00	1,493,913.69
210303	Цэвэр, бохир ус	1,714,380.00	1,681,062.87
2104	Хангамж, бараа материалын зардал	83,922,320.00	7,388,650.00
210401	Бичиг хэрэг	1,999,000.00	2,400,000.00
210402	Тээвэр, шатахуун	78,440,400.00	1,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,462,920.00	1,508,650.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,720,000.00	1,800,000.00
2105	Нормативт зардал	8,750,000.00	00.00
210502	Хоол, хүнс	8,750,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,360,000.00	4,742,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	300,000.00	279,900.00
210604	Урсгал засвар	2,060,000.00	4,463,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,370,000.00	3,548,400.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	5,370,000.00	3,548,400.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	577,939,724.00	89,053,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	575,708,824.00	86,701,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	990,000.00	594,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	222,750.00	223,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	298,695.00	340,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилогоо	66,000.00	44,000.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	323,000.00	772,000.00
210807	Газрын төлбөр	330,455.00	378,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	690,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	690,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	253,714,670.68	40,118,244.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,089,250.00	18,042,299.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	11,271,299.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,089,250.00	6,771,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	250,625,420.68	22,075,945.46
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	00.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	6,000,000.00	2,998,805.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	6,000,000.00	2,998,805.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,000,000.00	2,998,805.00
2200	Дотоод эх үүсвэрээр	6,000,000.00	2,998,805.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,000,000.00	2,998,805.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-6,000,000.00	-2,998,805.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	258,066,475.95	2,171,225.00	148,766,721.30	00.00	409,004,422.25
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	258,066,475.95	2,171,225.00	148,766,721.30	00.00	409,004,422.25
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	154,320,403.80	00.00	154,320,403.80
C08	2014 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	161,706,475.95	6,217,954.88	616,927,874.96	00.00	784,852,305.79
D01	2015 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	161,706,475.95	6,217,954.88	616,927,874.96	00.00	784,852,305.79
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	161,706,475.95	6,217,954.88	616,927,874.96	00.00	784,852,305.79
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	15,368,001.83	00.00	15,368,001.83
D09	2015 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	161,706,475.95	6,217,954.88	632,295,876.79	00.00	800,220,307.62

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	514,127,600.00	502,000,654.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	514,127,600.00	502,000,654.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	489,589,500.00	483,958,355.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	405,579,500.00	405,501,374.90
210101	Үндсэн цалин	204,206,900.00	205,187,163.47
210102	Нэмэгдэл	164,349,600.00	163,925,546.87
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,212,300.00	24,611,998.56
210104	Урамшуулал	11,810,700.00	11,776,666.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,555,800.00	50,687,673.08
210201	Тэтгэврийн даатгал	35,737,900.00	34,467,617.29
210202	Тэтгэмжийн даатгал	4,204,500.00	4,055,013.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,363,600.00	3,244,011.03
210204	Ажилгүйдлийн даатгал	840,900.00	811,002.79
210205	Эрүүл мэндийн даатгал	8,408,900.00	8,110,028.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,610,000.00	4,948,352.56
210301	Гэрэл, цахилгаан	3,150,000.00	1,773,376.00
210302	Түлш, халаалт	1,500,000.00	1,493,913.69
210303	Цэвэр, бохир ус	1,805,000.00	1,681,062.87
210304	Байрны түрээс	155,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,900,000.00	5,888,650.00
210401	Бичиг хэрэг	2,400,000.00	2,400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,520,000.00	1,508,650.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,800,000.00	1,800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,770,000.00	7,741,705.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	300,000.00	279,900.00
210602	Тавилга	3,000,000.00	2,998,805.00
210604	Урсгал засвар	4,470,000.00	4,463,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,500,000.00	3,548,400.00
210702	Дотоод албан томилолт	5,500,000.00	3,548,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,974,200.00	4,952,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,600,000.00	2,600,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	594,000.00	594,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	223,000.00	223,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	340,600.00	340,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилогоо	66,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	772,000.00	772,000.00
210807	Газрын төлбөр	378,600.00	378,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	700,000.00	690,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	700,000.00	690,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24538100.00	18042299.00

2132	Бусад урсгал шилжүүлэг	24,538,100.00	18,042,299.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,728,300.00	11,271,299.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,809,800.00	6,771,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	514,127,600.00	514,677,600.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	514,127,600.00	514,127,600.00
132001	Орон нутгийн төсвөөс	514,127,600.00	514,127,600.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	550,000.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	17	17
620001	Удирдах ажилтан	01	01
620002	Гүйцэтгэх ажилтан	11	11
620003	Үйлчлэх ажилтан	05	05

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар нь байгалийн нөөц баялгийг хамгаалах, нөхөн сэргээх, орчны экологийн тэнцвэртэй байдлыг хамгаалах, хүний амьдрах эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх, байгаль орчны чиглэлээр төрөөс баримталж буй бодлогыг аймгийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх, байгаль орчны хууль тогтоомжийн биелэлтэд төрийн болон технологийн хяналт тавих, байгаль орчны мэдээлэл сургалт, сурталчилгаа явуулах, орон нутгийн онцлогийг харгалзан аялал жуулчлал хөгжүүлэхэд, байгаль орчныг хамгаалахад чиглэсэн төсөл хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэн ажилладаг орон нутгийн харьяа байгууллага юм.

Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэн, байгальд ээлтэй, дэвшилтэт ногоон технологийг нэвтрүүлж, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглуулан, нөхөн сэргээлтийг эрчимжүүлэх замаар байгалийн үр өгөөжийг өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлж, байгальд ээлтэй тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхэд оршино.

Дээрх зорилгыг хэрэгжүүлэхэд дараах үйлчилгээг орон нутагт хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

1. Байгалийн нөөц баялгийг хамгаалах
2. Байгалийн нөхөн сэргээлтийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх
3. Байгалийн баялгийг зүй зохистой ашиглуулах
4. Байгалийн баялгийн төлөв байдалд мониторинг судалгаа хийж, шаардлагатай арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлэх
5. Байгаль орчны бохирдлыг бууруулж, хүний амьдрах эрүүл орчныг бүрдүүлэх
6. Байгаль хамгаалах үйлсэд иргэд байгууллага, аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдүүлэх
7. Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ,ОНБ, иргэдийн нөхөрлөлүүдэд мэргэжлийн болон арган туслалцаа үзүүлэх
8. Бүх нийтийн экологийн боловсролыг дээшлүүлэх
9. Орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэх
10. Байгаль орчны хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж хэрэгжүүлэх

Дээрх зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 3 чиглэл бүхий төлөвлөгөө гарган нийт 75 ажил төлөвлөснөөс гүйцэтгэл 100 хувь, чанар 96.4 хувьтай байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар байгалийн нөөц баялгийг хамгаалах, нөхөн сэргээх, орчны экологийн тэнцвэртэй байдлыг хамгаалах, хүний амьдрах эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх, байгаль орчны чиглэлээр төрөөс баримталж буй бодлогыг аймгийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх, байгаль орчны хууль тогтоомжийн биелэлтэд төрийн болон технологийн хяналт тавих, байгаль орчны мэдээлэл сургалт, сурталчилгаа явуулах, орон нутгийн онцлогийг харгалзан аялал жуулчлал хөгжүүлэх гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажилласан байна.

Тус байгууллага нь тайланд онд үйл ажиллагаандаа дараах хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөн ажилласан байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
- Ойн тухай хууль
- Амьтны тухай хууль
- Усны тухай хууль
- Байгалийн ургамлын тухай хууль
- Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол
- Засгийн газрын 2019 оны 5, 6, 7 дугаар тогтоол
- Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоол
- Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал
- Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тушаал

Тайлант онд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжид дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд 6, Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2, Хөдөлмөрийн тухай хуульд 3, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд 2, Ойн тухай хуульд 2, Байгалийн ургамлын тухай хууль 1, Амьтны тухай хууль 1, Усны тухай хууль 1, Төрийн албаны тухай хуульд 6 удаагийн нэмэлт өөрчлөлт орсон байна.
- Засгийн газрын 241 дүгээр тогтоолоор "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээ"-г шинэчлэн тогтоож, 2023 оны 07 дугаар сарын 01-ээс мөрдөж эхэлсэн.
- Засгийн газрын 308 дугаар тогтоолоор "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх журам"-ыг 2023 оны 08 дугаар сарын 23-нд баталж, мөрдсөн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагаа нь үндсэн үйл ажиллагаанд чиглэж, төсөв санхүү, нягтлан бодох бүртгэл болон шилэн данс, Төрийн хэмнэлтийн хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хийгээгүй байх тул дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Дотоод аудиторын чиг үүргийг хэрэгжүүлэх орон тоо байдаггүй тул аудитад ашиглах шаардлага үүсээгүй болно.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус газар нь Орхон аймгийн Засаг даргын 2023 оны А/255 дугаар захирамжаар баталсан "Орхон аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг ашиглаж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 15,368.0 мянган төгрөгөөр буюу 1.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	222,177.24	224,282.26	2,105.02
Үндсэн хөрөнгө	562,675.06	575,938.04	13,262.98
Нийт хөрөнгө	784,852.30	800,220.30	15,368.00
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	784,852.30	800,220.30	15,368.00
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	784,852.30	800,220.30	15,368.00

Дээрх хүснэгтээс харахад нийт хөрөнгө өмнөх оноос 15,368. мянган төгрөгөөр өсөхөд үндсэн хөрөнгийн данс нөлөөлжээ.

Мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй, 22,075.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Авлага, өр төлбөргүй ажилласан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 224,282.2 мянган төгрөг болж 2,105.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 15,802.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, үнэ төлбөргүйгээр нэмэлт данс болон байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 150,457.3 мянган төгрөгийн бараа материал авч 153,154.1 мянган төгрөгийн бараа материал зарлагдаж, 11,000.0 мянган төгрөгийн бараа материалыг Эрдэнэт-Ус ОНӨААТҮГ-т шилжүүлснээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 575,938.0 мянган төгрөг болж 13,262.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны шилжүүлж авсан хөрөнгөтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 800,220.3 мянган төгрөг болж 15,368.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээр ашигтай ажилласнаас шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 292,794.3 мянган төгрөг, нийт зарлагыг 292,794.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт зардлаас 68,645.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, орон нутгийн төсвөөс 361,439.4 мянган төгрөгөөр баталсан байна. Баталсан төсвийг 1 удаа өөрчилсөн бөгөөд 2023 оны 07 дугаар сарын 25-нд төвийн хуваарийг баталжээ.

Энэ нь Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоол хэрэгжсэнтэй холбоотой цалингийн санг тодотгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 152,688.2 мянган төгрөгөөр 1 удаа нэмэгдүүлж тодотгосон байна. Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхэд 514,127.6 мянган төгрөгийн санхүүжилт олгож, туслах үйл ажиллагааны орлого 550.0 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээр 95,000.0 мянган төгрөгийг зарцуулж, 22,075.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн нийт зардлын гүйцэтгэл 587,601.6 мянган төгрөг буюу 114.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардал дээр туслах үйл ажиллагааны орлого 550.0 мянган төгрөг, нэмэлт төсвийн 85,601.0 мянган төгрөгийг зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
УЛСЫН ТӨСӨВ					
1	71411 Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	514,127.60	587,601.65	(73,474.05)	114.30%
1.1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	489,589.50	569,559.35	(79,969.85)	116.30%
1.2	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	24,538.10	18,042.30	6,495.80	73.50%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн А/628 дугаар захирамжаар “Зэс фестивал” эвент арга хэмжээг зохион байгуулах зардалд 85,000.0 мянган төгрөг, 2023 оны 09 дугаар сарын 18-ны өдрийн А/701 дүгээр захирамжаар аялал жуулчлалын бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжин “АЙ-ТИ-ЭМ Mongolia” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох зардалд 10,000.0 мянган төгрөг төлөвлөснөөс нийт 85,601.0 мянган төгрөгийг зарцуулж үлдэгдэл 9,399.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит XIII хуралдааны 13/09 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар 2023 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалтыг баталсан байна. Үүнд:

- Шилжих хөрөнгө оруулалт-85,792.1
- Шинээр эхлэх хөрөнгө оруулалт/Барилга байгууламж-915,400.0
- Зөвлөх үйлчилгээ-65,000.0
- Тоног төхөөрөмж-2,598,500.0
- Төсөл хөтөлбөр-443,600.0 нийт 4,108,292.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Орхон аймгийн төрийн сангийн хэлтсийн эрх өгсний дагуу хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилтийг шилжүүлж тендер сонгон шалгаруулах, болон гүйцэтгэлийг орон нутгийн өмчийн газар хариуцан зохион байгуулсан. Хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийг гаргавал 15 ажлаас 14 ажил нь хийгдэж 1,088,712.9 мянган төгрөгийг зарцуулж, тусгай зориулалтын тоног төхөөрөмжийг худалдан аваагүй тул 2,575,979.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Харин Байгаль орчин аялал жуулчлалын газар нь 443,600.0 мянган төгрөгийн 23-н төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, 420,079.8 мянган төгрөгийг зарцуулан, төсөл хөтөлбөрийн хэрэгжилт 94.6 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний зохион байгуулах	2023.12.31	Арга хэмжээний тоо 10	Бүх нийтээр мод тарих хавар, намрын ажлыг зохион байгуулах, Ногоон Эрдэнэт хөтөлбөрийн хүрээнд мод тарих нийт талбайн зураг төслийг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх, Тарьсан модоо арчилъя аяныг зохион байгуулах, “Өрх бүр 5 ширхэг” мод арга хэмжээг зохион байгуулах, Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг дэмжих гэрээт ажилтан ажиллуулах, Гэр	100,000.0	91,856.9

				хорооллын айл өрхүүдэд тарих модны нарийвчилсан судалгаа хийх зэрэг 12 арга хэмжээг зохион байгуулж, бүх нийтээр мод тарих ажлын хүрээнд нийт 1.888.068 ширхэг мод тарьж, хөтөлбөр батлагдсанаас хойших хугацаанд өссөн дүнгээр 3.340.577 ширхэг мод тарьсан.		
2	Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах.	2023.12.31	Арга хэмжээний тоо 18	Ойн тухай хуулийн 17.1.5 дахь заалтын дагуу 2023 онд Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах 4 чиглэл 21 арга хэмжээ бүхий ажлын төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын 2022 оны 12/08 дугаар тогтоолоор батлуулж, аймгийн Засаг даргын 2023 оны А/148 дугаар захирамжийн дагуу дараах 18 арга хэмжээг зохион байгуулсан. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх 6 төрлийн анхааруулга санамж, тараах материал бэлтгэж, нийт 1680 ширхгийг хэвлэж, ой хээрийн бүсэд аялж зугаалж, түймэр тавьж болзошгүй 1200 гаруй иргэнд анхааруулга санамж өглөө. Ойн сангийн бүсэд үйл ажиллагаа эрхэлж байгаа Ар булаг, Happy land, Габилан, Элсэн нүүр зэрэг амралт сувиллын газруудын ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажил, түймэртэй тэмцэх-бэлтгэл бэлэн байдлыг шалгалаа. Хуурайшилтын улиралд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх нэгдсэн хяналт шалгалтын ажлыг 53 удаа Сум дундын ойн анги, Баян-Өндөр, Жаргалант сумдын ЗДТГ-тай хамтран зохион байгуулж, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх мэдээлэл, анхааруулга сэрэмжлүүлгийг олон нийтэд хүргэх зорилгоор аймгийн байгаа 11 самбарт 14м2 авто стикер нааж, сэргээн засварлалаа. Мөн орон нутгийн EBS телевизээр цаг үеийн нэвтрүүлэг хийлгэж, 3 хоногийн хугацаанд олон нийтэд хүргэлээ.	18,000.0	17,200.0
3	Мод тарьсан, таримал ойн төгөл, ойн зурвас байгуулсан иргэн аж ахуйн нэгж байгууллагуудыг урамшуулах	2023.12.31	Өрхийн тоо 20	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалан "Ногоон Эрдэнэт" болзолт уралдааныг 2021 оноос 2024 оныг дуустал хугацаанд 2 үе шаттайгаар зохион байгуулахаар аймгийн Засаг даргын 2021 оны А/228 дугаар захирамжаар зарлалаа. 2023 онд 167.543 ширхэг мод тарьсан 28 иргэн, аж ахуйн нэгжид урамшуулал олгож Болзолт уралдаан эхэлснээс хойш идэвхтэй оролцсон, 176.268 ширхэг мод тарьж, ургуулж, орчны	20,000.0	19,745.0

				ногоон байгууламж нэмэгдүүлсэн 68 иргэнийг шалгаруулж, урамшуулал олголоо.		
4	Хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах.	2023.12.31	Хяналт шалгалт зохион байгуулсан хүн/хоног 200	Хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх эргүүл, шалгалтын ажлыг ЦГ, АТТ, СДОА, Баян-Өндөр, Жаргалант сумдын ЗДТГ, Булган аймгийн БОАЖГ, Булган аймгийн Орхон, Сэлэнгэ, Хангал, Бугат сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагчтай хамтран 228 хүн хоног зохион байгуулж, 6 зөрчил илрүүлж, Зөрчлийн тухай хуулийн хялбаршуулсан журмаар 3 зөрчлийг шийдвэрлэж, Эрүүгийн хуулийн дагуу шийдвэрлэгдэх 3 зөрчлийг Цагдаагийн газарт шилжүүлэн шийдвэрлүүллээ	10,000.0	10,000.0
5	Хортон шавжийн түүвэр судалгаа хавар намар хийх	2023.12.31	Талбайн хэмжээ 13220 га	Ойн хортон шавжаас урьдчилсан судалгааны ажлыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар, Сум дундын ойн ангитай хамтран аймгийн нийт ойн санг бүрэн хамруулж 15000 га талбайд зохион байгууллаа. Судалгаагаар Баян-Өндөр сумын ойн сангийн 2694 га-д тархалттай, 856 га-д голомттой, Жаргалант сумын ойн сангийн 14000 га-д тархалттай, 5262 га-д голомттой болохыг тогтоолоо.	2,800.0	2,594.4
6	2023 оны хавар, намар тарьсан модны усалгаа хийх	2023.12.31	Усалсан талбайн хэмжээ 120 га	Бүх нийтээр мод тарих 2022 он, 2023 оны ажлын хүрээнд Чимээгүй хотын ойн зурвас, Тарлан толгойн таримал ойн төгөл, Гэр бүлийн ойн төгөл, Сархиа уулын ойн төгөл, А1001 авто зам дагуух ойн зурвас, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын хаягдлын аж ахуй ойн зурвас, Хангал голын голдирол дагуух ойн зурвас зэрэг газруудад байгуулсан нийт 121 га талбайд таригдсан 1 256 132 ширхэг модны усалгааны ажлыг Сум дундын ойн анги болон Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын 3 усны авто машинаар гүйцэтгүүллээ.	18,000.0	13,800.0
7	Өөрийн эзэмшлийн хашаанд нэн ховор төрлийн мод тарьж, ургуулсан иргэдэд борлуулалтын дэмжлэг үзүүлэх	2023.12.31	Худалдан авч урамшуулал олгосон модны тоо 1000	Баян-Өндөр сумын 3 иргэн, Жаргалант сумын 1 иргэний үржүүлсэн нэн ховор төрлийн таримал модонд борлуулалтын дэмжлэг олгож, Бүх нийтээр мод тарих хаврын ажлын хүрээнд ховор төрлийн 4 төрлийн модны 1000 ширхэг тарьц, суулгац худалдан авч, борлуулалтын дэмжлэг үзүүлж, бүх нийтээр мод тарих хаврын ажлын хүрээнд чимээгүй хотын ойн зурвас, Баян-Өндөр уулын Хүрэнбулагийн амны Гэр бүлийн ойн төгөл зэрэг газруудад олон нийтийн оролцоотой тарьж, ургуулах ажлыг зохион байгуулж, усалгаа арчилгааны ажлыг гүйцэтгэж байна.	20,000.0	20,000.0
8	Ойгоос мод бэлтгэх талбай тусгаарлалт	2023.12.31	Талбайн хэмжээ 102га	Аймгийн ИТХ-ын 2022 оны 12/04 дүгээр тогтоолын дагуу Жаргалант сумын ойн сангийн 102 га талбайд	7,650.0	7,650.0

	хийх			мод бэлтгэх талбай тусгаарлалтыг Сум дундын ойн ангиар гүйцэтгүүлж, Жаргалант сумын иргэдэд 800 м ³ мод бэлтгэх эрхийн бичиг олголоо.		
9	Агаарын бохирдлыг бууруулах мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх.	2023.12.31	Арга хэмжээ 7	<ul style="list-style-type: none"> • Аймгийн Засаг даргын 2022 оны А/759 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг агаарын бохирдлын эх үүсвэрийн тоо бүртгэлийг 13614 айл өрх, 11 аж ахуйн нэгж, байгууллагын 28 уурын зуух /хүчин чадлаар ялгаатай/, 24398 авто тээврийн хэрэгслийг хамруулан зохион байгууллаа. • Агаар бохирдуулагч суурин эх үүсвэрийн тоог бууруулах хүрээнд 2022-2023 онд гэр хорооллын 110 өрхөд Монгол гэрийн дулаалга, цахилгаан халаалтын багцЧИП-ийг олгож, яндангийн тоог буурууллаа. Мөн БОАЖЯ-аас хэрэгжүүлж буй хүлэмжийн хийг бууруулах төслийн хүрээнд 2-3 өрхөд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр, дулаалга, цахилгаан халаалтыг багцаар нь шийдвэрлэж, карбон кредит тооцуулах туршилтын ажлыг зохион байгуулахаар бэлтгэл хангаж, гэр хорооллын нийт 480 иргэнийг сургалтад хамруулж, урьдчилсан судалгааны ажлыг эхлүүллээ. • Эрчим хүчний найдвартай эх үүсвэрийг бүрдүүлэх ажлын хүрээнд 35/6 кв-ын ЦРП-Өмнөд дэд станцыг 2x10000кВа-аар өргөтгөх ажил хийгдэж ашиглалтад оруулсан. Хэрэглэгчийг шинэ станцад шилжүүлэх ажил бүрэн хийгдэж дууссан. • Алслагдсан багуудын төрийн байгууллагууд, аж ахуйн нэгжүүд, айл өрхүүдийг бие даасан дулааны эх үүсвэрээр хангахаар НҮБ-ийн Хүүхдийн сан, ШУТИС-тай хамтран Яргуйт багт газрын гүний дулаан ашиглан багийн байр болон 28-р цэцэрлэгийг халаах ТЭЗҮ-г хийлгэлээ. • Гэр хорооллын дахин төлөвлөлт, шинэ суурьшлын бүсийг бий болгох, байгальд эзлэй, эрчим хүчний хэмнэлттэй, дулааны алдагдалгүй ногоон барилга байгууламжийг нэмэгдүүлэх, ажлын хүрээнд Баян-Өндөр сумын Эрдэнэ багийн 6 га талбайд 60 айл, Оюут багийн Сархиа уулын энгэрт 48 га талбайд 300 айлын амины орон сууцны төслийг бүх нийтэд танилцуулж, "Ногоон амины орон сууц"-ны мэдээллийн өдөрлөгийг зохион байгуулж, ногоон технологийн шийдлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 40 гаруй ААН оролцлоо. • Аймгийн хэмжээнд хийн хөдөлгүүртэй 1877ш, цахилгаан хөдөлгүүртэй 7ш, хосолсон хөдөлгүүртэй 9705ш тээврийн 	34,000.0	33,897.5

				<p>хэрэгсэл бүртгэгдсэн нь суурь түвшинтэй харьцуулахад хийн хөдөлгүүртэй 514 ширхгээр, цахилгаан хөдөлгүүртэй 7 ширхээр тус тус нэмэгдсэн байна. Цахилгаан автомашины хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор Leaf center ХХК-тай хамтран мэдээллийн өдөрлөгийг Амарын талбайд 4 өдрийн турш зохион байгуулж, 6 төрлийн цахилгаан автомашиныг нийт 10 мянга гаруй хүнд сурталчилж ажиллалаа.</p> <ul style="list-style-type: none"> • Эрдэнэт хотын агаарын чанарыг сайжруулах шинэчилсэн бүсийн зураг, бүсэд мөрдөх журам, Агаарын тухай хуулийн холбогдох заалтуудыг тусгасан гарын авлагыг бэлтгэн хэвлүүлж, Баян-Өндөр сумын ЗДТГ, гэр хорооллын 19 багийн ажлын албаны хэрэгцээнд олгож, мэдээллээр хангаж ажиллалаа. <p>ОББҮХ-ны хөрөнгө оруулалтаар Интеллигент технологи ХХК-ийн нийлүүлсэн 1100ш угаарын хий мэдрэгч төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах хүрээнд Баян-Өндөр уул, Говил багт тус тус сүлжээний антеныг тавиулж, айл өрхөд суурилуулахад бэлэн болголоо.</p>		
10	Зориулалтын бус газар хуримтлагдсан хог хаягдлын судалгааг хийж, цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах	2023.12.31	Цэвэрлэсэн хог хаягдлын хэмжээ /м³/ 950	<ul style="list-style-type: none"> • Эрдэнэт хотын эргэн тойронд, Булган аймгийн хил залгаа сумдын хилийн бүс нутгаар хуримтлагдсан эзэнгүй хог хаягдлыг цэвэрлэх ажлыг ажилгүй 20 иргэнийг түр ажлын байраар ханган зохион байгуулж, нийт 55 цэгийн 840м³ хог хаягдлыг бүрэн цэвэрлэж, дарж, устгууллаа. • Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 02 тоот албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах хүрээнд: Орхон аймгийн хэмжээнд нийт 25 цэг байршилд 162 гаруй малын гаралтай хог хаягдал, сэг зэмийн байршлыг тогтоож, цэвэрлэж, ариутгал, халдваргүйтгэлийн ажлыг хийж гүйцэтгэлээ. • Орхон АЗЗА ТӨХК-ийн Дархан-Эрдэнэт чиглэлийн А1001 дугаартай 108 км, Эрдэнэт-Булган чиглэлийн А1002 дугаартай 29.7 км авто замууд, Эрдэнэт Төмөр замын хариуцсан замын дагуух 2 талын 50м хүртэлх газрын хог хаягдлыг 2 тн хог хаягдлыг цэвэрлүүлж, бохирдлыг бууруулж ажиллалаа. • Мөн Булган аймгийн Бугат сумын нутаг, Овоот хөтлийн баруун талд Жавхлант харгуй ХХК, Өлзий хутгийн наран ХХК-иудын гаргасан карьерын орчинд хуримтлагдсан их хэмжээний хог хаягдлыг түрүүлж, орчны тархсан 320м³ хог хаягдлыг 	35,000.0	34,973.7

				<p>цэвэрлүүлээ.</p> <ul style="list-style-type: none"> Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 30 ААНБ-ууд 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд Эрдэнэт хотын эргэн тойронд, Булган аймгийн хөрш зэргэлдээ сумдын хил залгаа нутгаар хаягдсан хог хаягдлын цэвэрлэгээний ажлыг 370 гаруй хүний бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулж, 288м³ хог хаягдлыг цэвэрлэж, төвлөрсөн хог хаягдлын цэгт дарж устгууллаа. 		
11	Орхон аймгийн Жаргалант сумын Улаантолгой багийн нутаг дэвсгэрт буюу тасгийн тогoyд эвдэрч эзэнгүй орхигдсон 1.5га газарт технекийн нөхөн сэргээлт хийх	2023.12.31	Нөхөн сэргээсэн талбайн хэмжээ 1.5 га	Орхон аймгийн Жаргалант сумын Улаантолгой багийн нутаг дэвсгэрт буюу Тасгийн толгойд эвдэрч, эзэнгүй орхигдсон 1.5 га газрын техникийн нөхөн сэргээлтийн ажлыг нөхөн сэргээлтийн мэргэжлийн байгууллагын эрхтэй ӨҮ БИ БИ Таун ХХК-тай гэрээ байгуулан БОНХАЖС-ын 2015 оны А/138 дугаар тушаалаар батлагдсан уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлалын дагуу гүйцэтгүүлж ажлын гүйцэтгэлийг газар дээр нь аймгийн Засаг даргын 2020 оны А/540 дүгээр Захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг шалгаж, танилцан актаар хүлээн авлаа.	16,000.0	16,000.0
12	Орхон аймгийн Жаргалант сумын иргэдийн гар худгуудыг шинжилгээнд хамруулах	2023.12.31	Худгийн тоо 60	<p>Орхон аймгийн Жаргалант сумын иргэдийн гар худгуудын усыг чанарын шинжилгээнд хамруулах ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгууллаа.</p> <p>Тус ажлын хүрээнд хими, нянгийн хосолсон 50 усны дээж авч, аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтсийн итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлээ.</p> <p>Жаргалант сумын ихэнх иргэд унд ахуйн усаа өрөмдмөл худгаас авдаг бөгөөд гар худгуудыг газар тариалангийн усалгаанд зарим тохиолдолд ашигладаг.</p> <p>Усны нянгийн шинжилгээгээр судалгаанд хамрагдсан уст цэгт MNS ISO 6222:1998 шинжилгээний стандартаас шинжилсэн ББЕТ 100 мл усанд байх хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнд байна.</p> <p>Мөн шинжилгээнд хамрагдсан бүх уст цэгүүдэд байвал зохих фторын ионы хэмжээ Монгол Улсын ундны усны MNS 0900.2018 стандарт хэмжээнд зааснаас хэт бага, усны ерөнхий химийн шинжилгээний дүнд магни болон кальци-ийн ионы агууламж бага зэрэг өндөр, үүнээс шалтгаалан зарим уст цэгт хатуувтар ус илэрсэн</p>	12,000.0	12,000.0

				байна.		
13	Аймгийн хэмжээнд ашиглагдаж байгаа гүний өрөмдмөл худгуудын мэдээллийн санг цахим хэлбэрт шилжүүлэх	2023.12.31	Уст цагийн тоо 531	<p>Орхон аймгийн хэмжээнд ашиглагдаж байгаа гүний өрөмдмөл худгуудын мэдээллийн санг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг гэрээний дагуу гүйцэтгүүлээ. Үүнд:</p> <p>-Баян-Өндөр, Жаргалант сумын усны нэгдсэн мэдээллийн санд нийт 574 гүний худгуудын мэдээллийг шинэчлэн орууллаа.</p> <p>-Ашиглалттай худгуудыг сонгож, албан хэрэгцээнд ашиглах зориулалтаар зураглалыг аймаг, сум, багаар боловсруулсан</p> <p>-Мөн гүний худгуудын мэдээллийг нарийвчлан гаргаж, байгууллагын http://boajg.or.gov.mn/ вэб сайттай холбож, цахим хэлбэрт шилжүүлээ.</p> <p>-Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журмын дагуу цахим мэдээллийн сангийн мэдээлэлд түшиглэн худаг тус бүрд усны онцгой хамгаалалтын бүсийн зураглалыг татаж орууллаа.</p> <p>-Газрын доорх усны мэдээлэл нь нууцын зэрэглэлтэй, хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглагдах тул цаашид шинээр худаг гаргах, цооног өрөмдөх зөвшөөрлийг цахим мэдээллийн сангийн мэдээлэлд тулгуурлан шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлээ.</p>	7,000.0	7,000.0
14	Байгаль орчны багц хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор холбогдох хууль, хяналтын байгууллагууд, идэвхтэн байгаль хамгаалагч болон олон нийтийн байцаагчидтай хамтран хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах.	2023.12.31	Хяналт шалгалтын хүн/хоногийн тоо 200	<p>Байгаль орчны багц хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор ОБГ, ЦГ, АТТ, СДОА, Баян-Өндөр, Жаргалант сумдын ЗДТГ, Булган аймгийн БОАЖГ, Булган аймгийн Орхон, Сэлэнгэ, Хангал, Бугат сумдын БОХ улсын байцаагч, Байгаль хамгаалагчидтай 2023 онд хамтран ажиллах хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг боловсруулж батлуулан 2023 оны жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөт шалгалтыг 31 байгууллагад, төлөвлөгөөт бус шалгалтыг хамтарсан хэлбэрээр 28 удаа зохион байгуулж нийт 53 зөрчлийг илрүүлснээс 27 зөрчлийг газар дээр нь таслан зогсоож 25 зөрчилд захиргааны арга хэмжээ авч ажилласан. Үүнээс ойн тухай хуулиар 6 зөрчил илэрснээс цагдаагийн газарт 3, хялбаршуулсан журмаар 3 зөрчлийг шийдвэрлэж, Амьтны тухай хуулиар 2, усны тухай хуулиар 8, хог хаягдлын тухай хуулиар 6 зөрчлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу захиргааны арга хэмжээг авч</p>	15,000.0	15,000.0

				ажилласан. Өдөр тутмын төрийн хяналт шалгалтын ажлыг 228 удаа зохион байгуулснаас давхардсан тоогоор 40 байцаагч, байгаль хамгаалагч, мэргэжилтнүүд оролцож, хууль бус зөрчил гаргах гэж байсан 23 иргэн, 4 ААНБ-ын үйл ажиллагааг газар дээр нь таслан зогсоож зөрчлөөс урьдчилан сэргийлэн, байгаль орчны багц хууль тогтоомж, зөрчлийн тухай хууль тогтоомжийг сурталчлан заавар зөвлөгөө өгч, тогтмол хяналт тавин ажиллалаа.		
15	Идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулж урамшуулах	2023.12.31	Урамшуулал олгосон идэвхтэн байгаль хамгаалагчдын тоо 6	Монгол улсын БОНХАЖ-ын сайдын А-110 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт "Идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулах, ажлын үр дүнгээр урамшуулах тухай" журам, Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн Ээлжит XIII хуралдааны 13/09 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт "Аймгийн байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардлаар 2023 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ"-ний 2.4.15 дахь заалтын дагуу 6 идэвхтэн байгаль хамгаалагчийг томилж ажлын үр дүнгээр урамшуулал олгож ажиллалаа.	36,000.0	28,043.9
16	Усны тоо бүртгэлийн ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах /Байгаль орчны усны статистик мэдээ боловсруулахад шаардлагатай тоон мэдээлэл цуглуулах судалгааны ажил хийх/	2023.12.31	Уст цэгийн тоо 700	Орхон аймгийн хэмжээнд Усны тоо бүртгэлийн судалгааны ажлыг БОАЖГ, Баян-Өндөр, Жаргалант сумдын ЗДТГ, багуудын ажлын алба, идэвхтэн байгаль хамгаалагчидтай хамтран зохион байгуулж, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-86 дугаар тушаалаар баталсан "Улсын усны мэдээллийн сан бүрдүүлэх үзүүлэлт, хөтлөх журам"-ын дагуу усны тоо бүртгэлийн мэдээг аймгийн усны мэдээллийн санд орууллаа. Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт 323 худаг, 15 булаг, 4 гол, 2 цэвэрлэх байгууламж, 15 усан сан, хөв цөөрөм, 23 үерийн хамгаалалтын далан, 25 цооног, Жаргалант сумын нутаг дэвсгэрт 251 худаг, 28 булаг, 6 гол, 1 цэвэрлэх байгууламж, 3 усан сан, хөв цөөрөм, 3 услалтын систем, 1 үерийн хамгаалалтын далан, 1 хяналтын цооногийг тус тус тоолж, аймгийн хэмжээнд нийт 701 уст цэгийг бүртгэлжүүлсэн.	5,500.0	5,500.0
17	Ус бохирдуулсны төлбөрийн эрх зүйн орчны шинэчлэлийн талаарх сургалт зохион	2023.12.31	Сургалтын тоо 2	БОАЖЯ, Усны газар, Орхон-Чулуут голын сав газрын захиргаатай хамтран томоохон ус ашиглагч үйлдвэр, аж ахуйн нэгжүүд, холбогдох мэргэжлийн байгууллагуудыг хамруулсан Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар нэгдсэн	3,000.0	2,975.0

	байгуулах			<p>хэлэлцүүлгийг зохион байгууллаа.</p> <p>Хэлэлцүүлэгт 28 байгууллагын нийт 68 оролцогч хамрагдаж, Усны тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиудын хэрэгжилт орон нутагт хэрхэн хангагдаж байгаа талаар нэгдсэн мэдээллийг өглөө.</p> <p>Мөн Гал сэнтий ХХК, Зэс эрдэнийн хувь ХХК, Эрдмин ХХК, Ачит Ихт ХХК-ийн ус ашиглалтын үйл ажиллагаа болон Эрдэнэт хивс ХХК, Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн ус ашиглалт болон хаягдал усыг эргүүлэн үйлдвэр, үйлчилгээнд ашиглаж буй үйл ажиллагаатай газар дээр нь танилцах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хаягдал уснаас хяналтын сорьцын шинжилгээ авах зэрэг ажлуудыг хамтран зохион байгууллаа.</p>		
18	Олон улсын эко сургууль хөтөлбөрт хамрагдаж буй ЕБС, цэцэрлэгүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	2023.12.31	Хамрагдсан сургуулийн тоо 13	<p>БОАЖЯ, БШУЯ хамтран Тогтвортой хөгжлийн боловсрол II төслийн зорилтот үйл ажиллагааг орон нутгийн "Ногоон хөгжлийн бодлого"-оо батлан хэрэгжүүлж буй 6 аймаг, Нийслэлийн 2 дүүргийн нийт 30 сургуульд "Сургуулийн менежментэд сургууль бүхлээрээ ажиллах арга хандлага (СБААХ)-ыг нэвтрүүлэх замаар тогтвортой хөгжлийн төлөөх загвар сургууль"-ийг хөгжүүлэхээр Техникийн зөвлөн зохицуулах үндэсний болон орон нутгийн багийн гишүүн байгууллагуудтай хамтран ажиллаж тодорхой үр дүнгүүд гарч байна.</p> <p>Швейцарын хөгжлийн агентлаг Тогтвортой хөгжлийг дэмжих зорилгоор олон төсөл хөтөлбөрийг Монголд хэрэгжүүлдэг. Энэ удаа "Ногоон хөгжлийн бодлого"-д суурилсан тогтвортой хөгжлийн дунд хугацааны баримт бичгээ боловсруулан хэрэгжүүлж буй Архангай, Булган, Орхон, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймаг болон Улаанбаатар хотын Баянгол, Сонгино хайрхан дүүрэгт хэрэгжүүлсэн төслүүдийн үр дүнгээ танилцуулах үндэсний чуулган Улаанбаатар хотод 3 хоногийн хугацаанд зохион байгуулагдлаа. Тус нэгдсэн чуулганд Орхон аймгаас төсөл хэрэгжүүлсэн 4 сургуулийн удирдлага, багш, сурагчид, БОАЖГ, БШУГ-ын холбогдох мэргэжилтнүүд нийт 112 хүний бүрэлдэхүүнтэй оролцлоо.</p> <p>"Тогтвортой хөгжлийн боловсрол-II" төсөлд хамрагдсан Орхон аймгийн</p>	18,000.0	18,000.0

				<p>ЕБ-ийн сургуулиуд дараах төслүүдийг хамтран амжилттай хэрэгжүүлж дууслаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • 4 дүгээр сургууль - "Өв уламжлал, түүх соёлын өргөө" • 5 дугаар сургууль - "Агаарын чанар - аюулгүй орчин" • 14 дүгээр сургууль - "Хэрэгцээ – Хэрэглээ - Хэмнэлт" • 15 дугаар сургууль - "Өвлийн хүлэмж" <p>Мөн Олон улсын Эко сургууль, цэцэрлэгт хөтөлбөрт Орхон МСҮТ, 26, 4, 15-р цэцэрлэгүүд шинээр хамрагдаж, 1, 3, 7, 13, 20-р сургуулиуд, 17 болон Бялзуухай цэцэрлэгүүд хамтран ажиллах саналаа өгснөөр эко сургууль, цэцэрлэгийн тоог 11-ээр нэмэгдүүллээ.</p>		
19	Байгаль орчны салбарын тэмдэглэлт өдрүүдийг орон нутагт сурталчлах ажлыг зохион байгуулах.	2023.12.31	Арга хэмжээний тоо 5	<p>Байгаль хамгаалах хаврын сарын аяныг 04 дүгээр сарын 15-аас 05 дугаар сарын 15-ны өдрийн хооронд зохион байгуулалтын чиглэлээр 13, сургалт сурталчилгааны чиглэлээр 5 ажлыг тус тус төлөвлөн батлуулж хэрэгжүүлж ажиллалаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Салбарын байгууллагуудтай хамтран нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж 36 төрлийн 2600 орчим гарын авлага, ном товхимол, заавар зөвлөмж, тараах материалыг бэлтгэж 350 гаруй иргэд, 16 аж ахуйн нэгж байгууллагуудад заавар, зөвлөгөө өгч, гарын авлага материалаар хангаж, сурталчлан ажиллалаа. • Тэрбум мод үндэсний хөдөлгөөн, "Ногоон Эрдэнэт" хөтөлбөрийн хүрээнд хаврын мод тарих ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулан төрийн болон ТББ, айл өрхүүдийн оролцоотой нийтдээ 348527 мод тарьж усалгаа арчилгааг хийж байна. • Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, эргүүл шалгалтын хүрээнд 250 орчим иргэдэд зөвлөмж, санамж өгч ажиллалаа. • Булган аймгийн БОАЖГ-тай хамтран амралт, сувиллын газруудын эко ариун цэврийн байгууламжийг шинэчлэх чиглэлээр хамтарсан зөвлөгөөн зохион байгуулсан. <p>Байгаль хамгаалах намрын сарын аяныг "Иргэн бүр байгаль хамгаалагч" уриа дор 10-р сарын 09-өөс 11-р сарын 09-ны хооронд зохион байгуулалт, сурталчилгааны чиглэлээр нийт 12 арга хэмжээг</p>	15,000.0	13,970.0

				<p>төлөвлөн бүх нийтэд хандсан арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа. Аяны хүрээнд салбарын байгууллагуудтай хамтран нээлттэй хаалганы өдөрлөг 2 удаа, аялал жуулчлалын үзэсгэлэн, БОАЖЯ, НҮБ-ын ХХ-ийн Биофин төсөл, Монголын байгаль орчны иргэний зөвлөлтэй хамтран байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар нэгдсэн сургалт зэрэг томоохон арга хэмжээг зохион байгууллаа.</p>		
20	<p>Байгаль хамгаалах хавар, намрын аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулах.</p>	2023.12.31	<p>Зохион байгуулсан арга хэмжээний тоо 2</p>	<p>Байгаль хамгаалах хаврын сарын аяныг 04 дүгээр сарын 15-аас 05 дугаар сарын 15-ны өдрийн хооронд зохион байгуулалтын чиглэлээр 13, сургалт сурталчилгааны чиглэлээр 5 ажлыг тус тус төлөвлөн батлуулж хэрэгжүүлж ажиллалаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Салбарын байгууллагуудтай хамтран нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж 36 төрлийн 2600 орчим гарын авлага, ном товхимол, заавар зөвлөмж, тараах материалыг бэлтгэж 350 гаруй иргэд, 16 аж ахуйн нэгж байгууллагуудад заавар, зөвлөгөө өгч, гарын авлага материалаар хангаж, сурталчлан ажиллалаа. • Тэрбум мод үндэсний хөдөлгөөн, "Ногоон Эрдэнэт" хөтөлбөрийн хүрээнд хаврын мод тарих ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулан төрийн болон ТББ, айл өрхүүдийн оролцоотой нийтдээ 348527 мод тарьж усалгаа арчилгааг хийж байна. • Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, эргүүл шалгалтын хүрээнд 250 орчим иргэдэд зөвлөмж, санамж өгч ажиллалаа. • Булган аймгийн БОАЖГ-тай хамтран амралт, сувиллын газруудын эко ариун цэврийн байгууламжийг шинэчлэх чиглэлээр хамтарсан зөвлөгөөн зохион байгуулсан. 	8,000.0	7,423.4

				хэрэгжилтийн талаар нэгдсэн сургалт зэрэг томоохон арга хэмжээг зохион байгууллаа.		
21	Байгаль орчны төлөв байдал, нөөцийн өөрчлөлтийн 2021-2022 оны тайланг мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэх	2023.12.31	Тоо хэмжээ 200	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5, 16.1.6, 35 дугаар зүйлийн 35.1 дэх заалтын дагуу Байгаль орчны төлөв байдал, байгалийн нөөцийн 2 жил тутамд эмхэтгэн гаргадаг тайланг 2021-2022 оны байдлаар 5 бүлгийн хүрээнд боловсруулан гаргалаа. Уг тайланд байгаль орчны салбарын байгууллагуудын мэдээ, судалгаа, статистик тоон мэдээллийг өөрчлөлт, дүгнэлт, зөвлөмжийн хамт нэгтгэн 200 ширхгийг хэвлүүлж бүх нийтэд хүргэлээ.	9,600.0	9,600.0
22	Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын дэлгэрэнгүй мэдээлэл бүхий газрын зургийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, олон нийтэд хүргэх	2023.12.31	Тоо хэмжээ 2670	Аймгийн аяллын газрын зургийг анх удаа мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлсэн бөгөөд нутаг дэвсгэрийн хэмжээ, онцлогоос шалтгаалан 100 000 масштабтайгаар 2 сумын нутаг дэвсгэр дээрх түүхэн цаг үед холбогдох хиргисүүр булш, түүх соёлын дурсгалт зүйлсийг аймгийн музейн бүртгэл мэдээллийн санд үндэслэн газрын байршил координатын дагуу уул ус, газар нутгийн нэршлийн хамт тус тус байршуулан англи, монгол хэлээр 4500 ш хийж гүйцэтгүүлэн зорин ирэх жуулчдыг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, улмаар мэдээллийг түргэн шуурхай, хүртээмжтэй нэг дороос авах боломжийг бүрдүүлэн ажиллалаа	13,350.0	13,350.0
23	Баян-Өндөр сумын гэр хорооллын багуудын нүхэн жорлонгоос үүдэлтэй хөрс, гүний усны бохирдлын нөлөөллийн түвшин тогтоох судалгааны ажлыг зохион байгуулах	2023.12.31	Судалгааны ажлыг зохион байгуулах багийн тоо 2	Орхон аймгийн Баян-Өндөр сумын гэр хорооллын багуудын нүхэн жорлонгоос үүдэлтэй хөрс, гүний усны бохирдлын нөлөөллийн түвшин тогтоох судалгааны ажлыг МУИС-ийн судалгааны багаар гүйцэтгүүлж, Цагаанчулуут, Уртын гол багийн өрөмдмөл 10 худаг /айл өрх/-ийг сонгож, гүний ус болон хөрснөөс химийн, элементийн, микробиологийн шинжилгээнүүдийг авч, 2 удаагийн давтан дээжлэлтийн ажлыг хийлээ. Тус ажлын хүрээнд аймгийн Эрүүл мэндийн газраас ундны ус, хөрсний бохирдолтой холбоотой гэдэсний халдварт өвчин болох цусан суулга, сальмонеллезын халдвар, суулгалт халдвар, гар, хөл амны өвчин, цочмог гепатит А гэсэн халдварт өвчлөлүүдийн дата мэдээллүүдийг авч, судалгаанд хамрагдсан бүсийн бохирдлын нөлөөллийн түвшин тогтоолоо.	19,700.0	19,000.0
	Дүн				443,600.0	420,079.8

Тайлант онд байгаль хамгаалах сангийн 443,600.0 мянган төгрөгийн 23 төсөл арга хэмжээ хэрэгжсэн байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардлаар 2023 онд шилжих хөрөнгө оруулалтын 1 арга хэмжээнд 85,792.1 мянган төгрөг, шинээр эхлэх хөрөнгө оруулалтын барилга байгууламжийн 8 арга хэмжээнд 915,400.0 мянган төгрөг, зөвлөх үйлчилгээний 2 арга хэмжээнд 65,000.0 мянган төгрөг, тоног төхөөрөмжийн 4 арга хэмжээнд 2,598,500.0 мянган төгрөгийн нийт 3,664,692.1 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтыг баталсан. Хөрөнгө оруулалтын тендер сонгон шалгаруулалтын ажлыг Орон нутгийн өмчийн газар зохион байгуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлэх, санхүүгийн бүртгэл, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Гантуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Буян-Ундрах, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 28 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсөв 514,127.6 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 10,282.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага нь цахим дэлгүүрээс худалдан авалт хийх шаардлага гараагүй байна.

Төрийн хэмнэлтийн хуулийн хүрээнд авсан судалгаагаар тус газар нь орлогч дарга, зөвлөх ажиллуулаагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 159 талбарын мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцлийн асуудлыг үнэлэх асуудал үүсээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийсэн.

Завсрын аудитаар 313.6 мянган төгрөгийн 6 зөрчил илэрснээс жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар 207.1 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 2 албан шаардлага, 106.5 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлж ажилласан тул залруулагдсанд тооцов.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитыг Бэйкер Тилли Далайван Аудит ХХК гүйцэтгэсэн бөгөөд аудитаар нийт 6,126.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 193.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 5,785.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 147.8 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн байна. Төлбөрийн актыг 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр бүрэн барагдуулж, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдөр ирүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	193.7	1	193.7	100.0
Албан шаардлага	1	5,785.0	1	5,785.0	100.0
Зөвлөмж	2	147.8	2	147.8	100.0
Нийт дүн	4	6,126.5	4	6,126.5	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар төсөл хөтөлбөр, арга хэмжээний зардлыг анхаарч үзэх

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 64,906.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 64,906.9 мянган төгрөгийн алдааг залруулж тайлагналаа.

Залруулсан алдаа:

- Санхүүгийн байдлын тайланд тайлант үеийн үр дүнг 13,653.7 мянган төгрөгөөр дутуу, мөнгөн гүйлгээний тайланд 2,998.8 мянган төгрөгийн худалдан авсан хөрөнгийг биет хөрөнгө худалдан авсан зардалд тусгаагүй, үндсэн хөрөнгийн дансанд 17,611.0 мянган төгрөгийн хөрөнгийг илүү, 23,799.8 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг илүү, бараа материалын дансанд 6,530.0 мянган төгрөгийн бараа материалыг дутуу илэрхийлснийг тус тус залруулав.
- Цалин болон амралтын нөхөн олговор давхардуулан олгосон 207.1 мянган төгрөгийг аудитын явцад суутган тооцсон.
- Ээлжийн амралтын нөхөн олговор 106.5 мянган төгрөгийг дутуу олгосныг нөхөн олгосон.
- Жилийн эцсийн байдлаар бараа материалын тайланд 166,259.2 мянган төгрөгийн бараа материал орлогод авч, 164,154.1 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, журмын дагуу орлого, зарлага, шаардах хуудасны маягтыг хөтлөн тайлагнаж архивын нэгж болгосон байна.
- Тайлант онд 86,238.8 мянган төгрөгийн шатахуун зарцуулж, автомашины спидометрийн заалтыг жолоочийн тооцооны хуудсанд бичиж тайланг гаргасан байна.
- Байгууллагын даргын А/30 дугаар тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг албан хаагч бүрийн карттай тулган баталгаажуулж, актлах хөрөнгийн жагсаалтыг гаргаж өмч хамгаалах зөвлөлд өгсөн.
- Дотоод хяналтын төлөвлөгөөг 2 зорилтын хүрээнд 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж биелэлтийг гаргаж 97.2 хувьтай тайлагнасан тул тус бүр залруулагдсанд тооцов.

5.1 Төлбөрийн акт

Шатах тослох материалаас 265.0 мянган төгрөгийн бензин зарцуулсан ч анхан шатны баримт байхгүй, байгууллагын бараа материалын үлдэгдэлд түүвэрлэн биет тооллого хийхэд 300.0 мянган төгрөгийн бараа материал дутсанд тус бүр 2 төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Байгаль орчны салбарын тэмдэглэлт өдрүүдийг орон нутагт сурталчлах ажлыг зохион байгуулах арга хэмжээнд зориулж 7,700.0 мянган төгрөгөөр гарын авлага, ном хэвлүүлж нөөцлөн төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсанд албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, бүрүү тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг бүрүү тайлбарласан /бүрүү ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

1. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Худалдан авч орлогоор бүртгэсэн бараа, ажил үйлчилгээний тоо хэмжээ, үнийн дүнг цахим төлбөрийн баримтад нийт дүнгээр бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5-д "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бараа, ажил, үйлчилгээний анхан шатны баримтыг холбогдох хууль, журамд нийцүүлж, бүртгэж тайлагнах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн		
							Тоо	Дүн	Тоо	Дүн				
Санхүүгийн байдлын тайланд тайлант үеийн үр дүнг 13,653.7 мянган төгрөгөөр дутуу	1	13,653.7			1	13,653.7			1	13,653.7				
Мөнгөн гүйлгээний тайланд 640.0 мянган төгрөгийн худалдан авсан хөрөнгийг биет хөрөнгө худалдан авсан зардалд тусгаагүй.	1	2,998.8	1	2,998.8					1	2,998.8				
Бараа материалын дансанд 6,530.0 мянган төгрөгийн бараа материалыг дутуу	1	6,530.0	1	6,530.0					1	6,530.0				
Үндсэн хөрөнгийн дансанд 17,611.0 мянган төгрөгийн хөрөнгө, 23,799.8 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг тус бүр илүү	1	41,410.8			1	41,410.8			1	41,410.8				
Цалин болон амралтын нөхөн олговор 1 хоногээр давхардуулан 207.1 мянган төгрөгийг илүү олгосон.	1	207.1			1	207.1			1	207.1				
Ээлжийн амралтын нөхөн олговрыг 1 ажилтанд 106.5 мянган төгрөг дутуу олгосон	1	106.5			1	106.5			1	106.5				
Дүн	6	64,906.9	2	9,528.8	4	55,378.1			6	64,906.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил				Төлбөрийн акт				Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шатах тослох материалаас 265.0 мянган төгрөгийн бөмбөн зарцуулсан ч анхан шатны баримт байхгүй байна.	1	265.0	1	265.0												

1	300.0	1	300.0							
1	7,700.0			1	7,700.0					
1	371.8					1	371.8			
4	8,636.8	2	565.0	1	7,700.0	1	371.8			
Дүн										

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил				Үүнээс					
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Дүн										